



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар Б/35

Хэрлэн сум

Ж.Гантулгад ажил хавсран
гүйцэтгэсний нэмэгдэл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2, 57.2.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 358 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн даргаар томилогдсон аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Жаргалын Гантулгад ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс үндсэн цалингийн 20 хувиар тооцож олгосугай.

2.Ж.Гантулгын нэмэгдлийг холбогдох журмын дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Ч.Баярцолмон)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ